



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 767

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 64 дүгээр тэмдэглэлийн 3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн “Монгол шуудан” хувьцаат компанийн 2021 он, 2022 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 135.3 (нэг зуун гучин таван сая гурван зуун мянга) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Монгол шуудан” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

2.1. Компанийн эд хөрөнгийн ашиглалт, захиран зарцуулалтын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах.

3. “Монгол шуудан” хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Б.Анхбаатар)-д дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

3.2. Компанийн нэр дээр бүртгэлтэй, эзэмшил тодорхойгүй болон баталгаажилт хийгдээгүй 11 ширхэг, 9344 м² газрыг баталгаажуулах, төрийн мэдээллийн “ХУР” системд залруулга хийлгэх, үнэлж бүртгэлд тусгах арга хэмжээ авч ажиллах;

3.3. 2022 онд шинээр авсан, эзэмших/ашиглах эрхийн 4 ширхэг, 22,674.0 м² газрыг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх;

3.4. Компанийн үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх журам болон жишиг үнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулж, түүнийг мөрдөн ажиллах;

3.5. “Ард пропертиз” ХХК-с хандиваар хүлээж авсан 689.3 (зургаан зуун наян есөн сая гурван зуу) сая төгрөгийн хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу хойшлогдсон орлогоор залруулан бүртгэх;


123007297
36-r huraldaan.docx

3.6.“Ард санхүүгийн нэгтгэл” ХК-тай хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомжид нийцүүлэх, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгах;

3.7.Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрмийн 5.1.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийнэ” гэж заасныг мөрдөн ажиллах;

3.8.Тогтоолын биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.



Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
767 дугаар тогтоолын хавсралт

“Монгол шуудан” ТӨХК-д
хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчлийн утга	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Компанийн эзэмшил/ашиглалт бүхий газрын үнэлгээг хийж санхүүгийн тайланд тусгаагүй.	4 ш, 9344 м2	Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тогтоолын дагуу үнэлж, Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолд заасны дагуу бүртгэлд тусгах.
2	Компанийн нэр дээр бүртгэлтэй, эзэмшил тодорхойгүй, баталгаажилт хийгдээгүй газар эзэмших/ашиглах эрх.	11 ш, 22674 м2	Төрийн мэдээлэл солилцооны ХУР сиситемд байгаа мэдээлэлтэй тулгалт хийж хууль тогтоомжийн хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллах
3	Худалдан авах ажиллагааны хуулийн холбогдох заалтыг зөрчсөн.	135.3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйл, 8.4, 8.6 дах заалтыг мөрдөн ажиллах.
4	"Ард санхүүгийн нэгдэл" ХК-иас хүлээн авсан хандивын хөрөнгийг санхүүгийн тайланд бүртгэсэн боловч НБББББ-т заасныг хэрэгжүүлээгүй.	-	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасныг мөрдөн ажиллах.
	НИЙТ ДҮН:	135.3 (Нэг зуун гучин таван сая гурван зуу) сая төгрөг	

-----oOo-----